



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/14

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн 2020 оны хөрөнгө оруулалтын зардлаар “Илчит Сансар” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Бохирын өргөх станцын насосны ажиллагаа, ашиглалтанд шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Н.Батцэцэг (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

Б.Сүх-Эрдэнэ (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд:

Т.Эрдэнэбаяр (Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн байцаагч)  
Б.Дэлгэрдалай (Мэргэжлийн хяналтын газрын Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хөндлөнгийн төлөөлөл:

Ш.Чинболд (“Илчлэг Шивээ” ОНӨААТГ-ын захирал)

2. Өргөх станцын ашиглалтын явцад гарч буй бэрхшээл нөхцөл байдлын шалтгааныг судалж цаашид авах арга хэмжээний талаарх саналыг боловсруулан 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Н.Батцэцэг)-д даалгасугай.

ДАРГА



Д.СОДНОМ